

## БАРУУН БҮСИЙН МАХНЫ ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ АСУУДАЛД

Г.Бадамхорол\*

**Хураангуй:** Төр засгаас ХАА-н талаар явуулж буй бодлогын нэг чухал чиглэл нь МАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, тухайн бүс нутаг төдийгүй зэргэлдээх бүс нутгуудын оршин суугчдыг эрүүл хүнсний бүтээгдэхүүнээр хангах явдал юм. Иймд махны үйлдвэрлэлийн өнөөгийн байдлыг тодорхойлж цаашдын асуудлуудыг дэвшүүлэхийг хичээлээ. Экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний нэг төрөл болох мах, махан бүтээгдэхүүний нөөц нь нийт малын тооноос хамааралтай. Манай улс 1918 онд анх удаа малаа тоолж байсан бөгөөд түүнээс хойш малын тоо анх удаа 61,5 сая толгой боллоо.<sup>2</sup> Мал аж ахуйн салбар нь хүн амыг хүнсээр, боловсруулах үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах үндсэн эх булаг байсаар ирсэн одоо ч энэ ач холбогдлоо алдаагүй, мал аж ахуйн хөгжлөөс манай орны эдийн засаг ихээхэн хамааралтай хэвээр байна. Манай улсын хөдөө аж ахуйн салбар үүний дотор мал аж ахуй нь эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, экспортын орлого, дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд жинтэй байр суурь эзэлдэг. Энэ салбараас хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний 80 орчим хувийг үйлдвэрлэж байна.

**Түлхүүр үг:** мал аж ахуй, махны үйлдвэрлэл, жишсэн хүн ам.

### **Монгол улсын махны үйлдвэрлэл**

Манай улс бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг учраас улирлын шинж чанартай мах бэлтгэл хийгддэг онцлогтой.

2015 оны гүйцэтгэлээр манай улсын ДНБ-ий 13,6 хувийг хөдөө аж ахуйн салбарт үйлдвэрлэж, үүний 72,1 хувийг мал аж ахуйн салбар эзэлж байна.

---

\* МУИС-ийн Завхан сургууль, (Email) gbadmaa24@yahoo.com

<sup>2</sup> [www.nso.mn](http://www.nso.mn)

Харин баруун бүсийн хувьд энэ үзүүлэлтийг авч үзвэл, ДНБ-ий 45,4 хувийг хөдөө аж ахуйн салбарт, 15,8 хувийг аж үйлдвэрийн салбарт, 38,8 хувийг худалдаа үйлчилгээний салбарт үйлдвэрлэж байна.

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэнэ. Үүнээс үүдэн мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хөдөө аж ахуйгаас бэлтгэгдэж буй махны нийлүүлэлт, үйлдвэрийн аргаар боловсруулж, аюулгүй байдлын шаардлага хангасан махны хэмжээ, экспортын хэмжээг судлан үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 1. Монгол улсын махны үйлдвэрлэл, мян.тн,  
Үйлдвэрлэлийн төрлөөр

	2012	2013	2014	2015	2016
Хөдөө аж ахуйгаас бэлтгэсэн махны хэмжээ, нядалгааны жингээр	211,2	237,8	235,2	357,5	464,5
Үйлдвэрийн аргаар боловсруулсан махны хэмжээ	16.6	19.3	16.8	17.5	18,4
Экспортод гаргасан махны хэмжээ	4,3	4,1	3	5,2	6,1

Эх сурвалж: [www.mofa.gov.mn](http://www.mofa.gov.mn)

2015 оны дүнгээр 14.5 сая толгой мал хүнсэнд хэрэглэж, хөдөө аж ахуйгаас 357.5 мянган тонн махыг бэлтгэсэн нь өмнөх оныхоос 1.5 дахин буюу 65.8 хувиар нэмэгдсэн байна. Үйлдвэрийн аргаар 17.5 мянган тонн махыг боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний хэмжээ өмнөх онтой харьцуулахад 0.7 мянган тонноор нэмэгдэж, боловсруулалтын түвшин 4.9% байна. 2015 онд 5.2 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн экспортолсон нь 2014 оныхоос 2 дахин нэмэгдсэн байна.

## Хүснэгт 2. Монгол улсын махны дотоодын үйлдвэрлэл, хангамж

	2012	2013	2014	2015	2016
Жишсэн дундаж нэг хүний жилийн хүнсний хэрэгцээ*, кг	73	73	73	73	73
Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээ, мян.тн	188,4	192,5	196,8	200,8	204,9
Дотоодын үйлдвэрлэл, мян.тн **	263,4	299,3	291,7	448,3	582,7
Хангамжийн хувь	139,8	155,4	148,2	223,2	284,4

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

\*- ХХААЯ “Газар хөдлөлтийн гамигийн цөийн орон нутгийн хүн амын хүнсний нөөц тооцох аргачлал” гарын авлагад тусгасанаар

\*\* Монгол улсын статистикийн эмхэтгэлд тугасанаар

Манай улсын жишсэн хүн амын жилийн махны хэрэгцээ 2016 онд 284,4 хувиар хангагдсан байна.

### Баруун бүсийн махны үйлдвэрлэл

Монгол улсын нийт малын тоонд баруун бүсийн малын тооны эзлэх хувийн жингээр нийт махны дотоодын үйлдвэрлэлд эзлэх бүсийн махны үйлдвэрлэлийн хэмжээг тооцож үзэхэд дараах байдалтай байна.<sup>3</sup>

Манай улсын хүн амын хүнсний гол хэрэглээ болох махны үйлдвэрлэлийн 24,4 хувь буюу 142700 тн мах нь баруун бүсэд ногдож байна.

## Хүснэгт 3. Баруун бүсийн махны дотоодын үйлдвэрлэл, хангамж

	2012	2013	2014	2015	2016
Жишсэн дундаж нэг хүний жилийн хүнсний хэрэгцээ*, кг	73	73	73	73	73
Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээ, мян.тн	23,7	23,8	24,8	25,6	26,1
Дотоодын үйлдвэрлэл, мян. тн	62,1	71,5	70,2	109,3	142,7
Хангамжийн хувь	262	300,4	283	426,9	546,7

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

<sup>3</sup> Судлаачийн тооцоололоор

*\*- ХХААЯ “Газар хөдлөлтийн гамшгийн цөийн орон нутгийн хүн амын хүнсний нөөц тооцох аргачлал” гарын авлагад тусгасанаар*

Баруун бүсийн жишсэн хүн амын жилийн махны хэрэгцээ 2016 онд 546,7 хувиар хангагдсан байна. Үүнээс үзэхэд махны үйлдвэрлэл хангалттай байгаа бөгөөд үйлдвэрүүдийн хүчин чадлыг тодорхойлон экспортод гаргах боломжийг судлан үзлээ.

### **Баруун бүсийн махны үйлдвэрүүдийн хүчин чадал**

Баруун бүсийн хэмжээнд мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг бүртгэлтэй 15 үйлдвэр байгаа бөгөөд эдгээрээс одоогийн байдлаар 10 үйлдвэр нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ дотоодын зах зээлд болон экспортод гаргаж байна. Эдгээрээс 4 үйлдвэр буюу 40% нь экспортын эрхтэй байна. Баруун бүсийн 5 аймгаас Говь-Алтай аймаг нь махны үйлдвэргүй юм. Үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрүүд нь хоногт 440 бод, 1600 бог нядлах, 1680-3250 тн мах, махан бүтээгдэхүүн бэлтгэх хүчин чадалтай байна.<sup>4</sup> Мөн улирлын чанартай, бага хэмжээний үйлдвэрлэл явуулж, ихэнх нь зогсонги байдалтай байна. Эдгээр үйлдвэрүүд нь одоогийн байдлаар:

1. Үр ашиг муу. Дотоодын зах зээлд тогтвортой үйл ажиллагаа явуулдаггүй, хөрөнгө оруулалт, шинэчлэл хийгдээгүй байна.
2. Хүчин чадал ашиглалт муу байна.
3. Орон нутгийн зах зээлийн эрэлт бага байна. Учир нь Монголын уламжлалт зан заншилтай холбоотойгоор орон нутаг дахь махны хэрэглээний гол онцлог нь гар аргаар бэлтгэсэн махаа хэрэглэх сонирхолтой байдаг.
4. Жижиг үйлдвэрүүд учраас экспортын зах зээл рүү нэвтрэх чадвар сул байна.

Иймд ажил эрхлэлтэй холбоотойгоор хүн амын амжиргааны түвшинг дээшлүүлэх, дотоодын махны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, чанартай эрүүл хүнснийг зорилтот зах зээл рүү чиглүүлэх шаардлагатай болохыг харуулж байна.

### **Баруун бүсийн махны экспортыг нэмэгдүүлэх боломж**


Зах зээлийн эдийн засагт шилжих үеэс эхлэн мах боловсруулах үйлдвэрүүд санхүүгийн хүндрэлд орж, хүчин чадал ашиглалт нь буурсанаас үйлдвэрийн аргаар боловсруулсан махны экспортын хэмжээ эрс багассан. Дэлхий дахинд

<sup>4</sup> Судлаачийн тоцоолол

махны хэрэглээ өсөж байгаа үед экологийн цэвэр орчинд байдаг манай орны бэлчээрийн мал аж ахуйн махны эрэлт хэрэгцээ нэмэгдэх хандлагатай байна.

ОХУ нь дэлхийн хамгийн том мах импортлогч орон бөгөөд түүхий махны нийт зах зээлийн 40% нь импортын мах эзэлдэг.<sup>5</sup> Баруун аймгуудаас Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан аймаг нь ОХУ-тай хиллэж байгаа нь давуу тал юм. Асар том зах зээл бүхий хөрш орнуудын эрэлт хэрэгцээг цаг алдалгүй мэдэрч, эрэлт хэрэгцээний онцлог шаардлагад тохируулан бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж үр ашигтай гэрээ хийж экспортыг нэмэгдүүлж чадвал асар өргөн боломж байна.

Зураг 1. Мал, мах экспортлох боомтууд, 2015 оны байдлаар



Баруун бүс махны экспортоо нэмэгдүүлэх хэд хэдэн давуу талтай.

1. Баруун бүс нь махны зах зээлийн томоохон импортлогч гүрнүүд болох БНХАУ, ОХУ-тай шууд хиллэдэг.
2. Казакстан улстай Баян-Өлгий аймаг нь хил залгаа оршиж хэл, соёл, зан заншлын хувьд ижил төсөөтэй байдаг нь энэ зах зээлийн онцлогт тохирсон мах, махан бүтээгдэхүүнийг экспортлох асар том боломж юм.
3. Увс аймагт үйл ажиллагаа явуулдаг “Увс мах маркет” ХХК нь гаднаас мах авч хадгалаад төв “Мах маркет” компанидаа нийлүүлдэг нь баруун бүстэй хиллэдэг улсууд төдийгүй бусад улс орнуудад нөөцөлсөн махыг экспортлох бүрэн боломжтой.

5 М. Эрдэнэчимэг “Баруун бүсийн мах махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх арга зам” доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл

## **Дүгнэлт**

Баруун бүс нь зах зээлд борлуулж болох махны нөөцийн хэмжээгээр бол шинэ үйлдвэр нэмэхгүйгээр, харин махны үйлдвэрүүд нь хүчин чадлаа бүрэн ашиглаж, үйлдвэрлэлээ тасралтгүй явуулах боломжийг бүрдүүлж ажиллах нь чухал.

Баруун бүсийн бизнес эрхлэгчид нь энэ чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх эхлэл сууриа тавьсан боловч тасралтгүй үр өгөөжөө өгөх, ашигтай ажиллах, гадаад зах зээлээ тэлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох талаар анхаарч ажиллахгүй байна. Энэ нь зах зээлийн судалгаа хийдэггүй, маркетингийн мэдлэг сул, санхүүгийн боломж тааруу, төрөөс үзүүлэх дэмжлэг бага гэж үзэж байна. Иймээс мах махан бүтээгдэхүүний экспортыг эрчимтэй хөгжүүлэхийн тулд зах зээлийн судалгаа, өнөөгийн махны үйлдвэрүүдийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх нь чухал болж байна.

Махны экспортыг дагаж боловсруулах жижиг дунд үйлдвэрлэлүүд хөгжих нөхцөл болж өгнө.

## **Ашигласан материал**

1. Монгол улсын статистикийн эмхэтгэл, УБ., 2015
2. Бизъяа Г. “ХАА бизнес ба мркетинг”. УБ., 2006
3. Газар хөдлөлтийн гамшгийн үеийн орон нутгийн хүн амын хүнсний нөөц тооцох аргачлал, ХХААЯ, 2015
4. Эрдэнэчимэг М. “Баруун бүсийн мах махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх арга зам” докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2011
5. ХАА-н улсын анхдугаар тооллого. УБ., 2011
6. [www.mofa.gov.mn](http://www.mofa.gov.mn)
7. [www.1212.mn](http://www.1212.mn)